

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН ТОЙМ СУДАЛГААНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

*Д.Нарантуяа Гамшгийн эрсдэлийн судалгаа
хариуцсан ЭША бөгөөд секторын эрхлэгч,
докторант, ОБЕГ-Гамшиг судлалын хүрээлэн*

Хураангуй

Дэлхий дахинд олон нийтийн оролцоотойгоор гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг чухлаар авч үзэх болсон. НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас 2015 онд зохион байгуулсан Дэлхийн бага хурлаас гаргасан “Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ” баримт бичигт “гамшгийн эрсдэлийн ойлголт, мэдлэгийг сайжруулах, хөрөнгө оруулалт хийх, гамшгийн эрсдэлийг удирдах засаглал болон бэлэн байдлын чадавхыг бэхжүүлэх, орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулах¹⁵” үйл ажиллагааг үндсэн чиглэл болгон тусгасан.

Үүнтэй уялдсан МУ-ын ЗГ-ын 2018 оны 68 дугаар тогтоолын 2.1-д “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ нь гамшгийн эрсдэлийн тойм судалгаанд үндэслэх бөгөөд гамшгийн эрсдэлийн тойм судалгааг үнэлгээ хийхэд шаардлагатай суурь мэдээллийг бүрдүүлэх, эрсдэлийг тодорхойлох зорилгоор хийнэ. 2.2.1-д “үндэсний хэмжээний тойм судалгааг онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон холбогдох салбарын эрдэмтэн судлаачдын хамтарсан ажлын хэсэг¹⁶” хийнэ гэж заасны дагуу 2019 онд ОБЕГ-аас томилогдсон ажлын хэсэг 14 аймгийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний тойм судалгааг хийж дүнг гаргасан. Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа болон цаашид авч хэрэгжүүлэх саналыг талаар товч өгүүллээ.

Түлхүүр үг: гамшгийн эрсдэлийн тойм үнэлгээ, олон нийтийн оролцоотой гамшгийн эрсдэлийг бууруулах

Оршил

Манай орны хувьд олон нийтийн оролцоотойгоор гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийх, эрсдэлийг бууруулах, гамшигтай тэмцэх чадавхыг сайжруулах, арга хэмжээ авах асуудлыг хэд хэдэн хууль тогтоомж, бодлогын баримт бичигт тусган оруулсан байдаг. Хууль, эрхзүйн орчны хувьд товч дурьдахад: Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Гамшгийн менежментийн тогтолцоог бэхжүүлж эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулж, төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангаж ажиллах нөхцөлийг бүрдүүлж, чадавхийг бэхжүүлнэ¹⁷”, мөн “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого” хөтөлбөрийн 2 дугаар үндсэн чиглэлд “Гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бэхжүүлж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төв, орон нутгийн төрийн байгууллага, мэргэжлийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог хангана¹⁸” гэж тодорхойлсон. Гамшгийн эрсдэлийг үнэлэх, гамшгаас хамгаалах чадавхыг сайжруулахад олон нийтийн оролцоог тодорхойлохдоо уг асуудлыг олон нийтийн түвшинд, гамшгийн эрсдэлийг удирдах, гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн даван туулах чадавхыг

сайжруулах хүрээнд гамшигтай тэмцэх олон нийтийн хүчин чадал, олон нийтийн удирдлага, хамтын ажиллагааны шинж чанар, олон нийтийн боломжит нөөцийг хэрхэн нэмэгдүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай юм. Мөн иргэдийн гамшигтай тэмцэх мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалт, дадлагыг тогтмолжуулах, гамшгийн төрөл бүр дээр ашиглах техник, тоног төхөөрөмжийг сайжруулах, тэдгээрийг ямарч үед ашиглаж чадах чадварыг эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах хэрэгтэй. Үүнийг зөвхөн сургалт, дадлагаар хийх боломжтой юм.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан гамшгийн эрсдэлийг үнэлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоолоор “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 125 дугаар тушаалаар “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ыг тус тус батлан хэрэгжүүлснээр гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийхэд оролцогч

Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журмын 1.4-т *“Гамшгийн эрсдэлийн үнэлгээг үндэсний, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн, салбарын, аж ахуйн нэгж, байгууллагын болон онц чухал объектын түвшинд хийнэ¹⁹”* гэсэн нь гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийх түвшин, цар хүрээг тодорхойлсон.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээг гамшгийн эрсдэлийн тойм судалгаа /ерөнхий үнэлгээ/, гамшгийн эрсдэлийн үнэлгээ /нарийвчилсан үнэлгээ/ гэсэн хоёр төрлөөр гүйцэтгэхээр заасан бөгөөд Гамшгийн эрсдэлийн тойм судалгааг үндэсний хэмжээнд, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, салбарын болон аж ахуйн нэгж байгууллагын түвшинд /ЗГ 67. 2 дугаар бүлэг/ тухайн шатанд байгуулагдсан Ажлын хэсэг, гамшгийн эрсдэлийн үнэлгээг “Хуулийн этгээд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, тодорхой салбар, аж ахуйн нэгж, байгууллага, улсын онц чухал объект, гал түймрийн онц аюултай барилга байгууламжийн түвшинд хийж, үнэлгээний тайлан гаргана /ЗГ 63, 7.3 дугаар зүйл/” гэж зохицуулсан.

Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийх материал, аргазүй:

Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа нь тухайн орон нутагт гамшгаас үүдэлтэй гарз хохирол учирч байгаа шалтгаан, энэ нь орон нутгийн хөгжил, ард иргэд, ялангуяа эмзэг бүлгийнхний амжиргаанд хэрхэн нөлөөлж байгааг, улмаар болзошгүй эрсдэлийг бууруулах, даван туулах чадавхыг бэхжүүлэх арга замыг бодитоор төлөвлөж, хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлага, иргэд, байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглүүлэх зорилготой үйл явц юм²⁰. Гамшгийн эрсдэлийн тойм судалгааг дараах зорилтын хүрээнд зохион байгуулна.

- Гамшгийн эрсдэлийг бууруулахад орон нутаг, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг судалгаанд суурилан бодитоор төлөвлөх;
- Энэхүү төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх арга замаа тодорхойлох;
- Уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтөнд тусгаж, уялдуулах нөлөөлөх;

Гамшгийн эрсдэлийн тойм судалгааны үе шатууд:

1 дүгээр үе шат:

ГЭТС хийх бэлтгэлээ хангах

- ГЭТС-ны үйл явцыг төлөвлөх
- Орон нутгийн төлөөллөөс бүрдсэн баг байгуулах, сургах
- Хоёрдогч мэдээллийг бэлтгэх 2 дугаар үе

шат:

Гамшгийн эрсдэлийн түвшинг тодорхойлох

- Болзошгүй аюулыг тодорхойлох
- Эмзэг байдал чадавхыг тодорхойлж дүн шинжилгээ хийх
- Гамшгийн эрсдэлийн түвшинг тодорхойлох

3 дугаар үе шат: *ГЭ-ийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах*

- Эмзэг байдлыг бууруулах үйл ажиллагааг тодорхойлох
- Үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжит болон шаардлагатай нөөцөө тодорхойлох
- Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга замаа тодорхойлох 4дүгээр

үе шат:

- Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нөлөөлөх
- Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох
- Судалгааны тайланг орон нутгийн удирдлагуудад танилцуулах, төсөв

хуваарилалтанд нөлөөлөх гэсэн үе шатуудыг хэрэгжүүлнэ.,

2019 онд ОБЕГ-ын Гамшгийн эрсдэлийн удирдлагын газар, Гамшиг судлалын хүрээлэнгийн хамтарсан ажлын хэсэг Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд гамшгийн эрсдэлийн тойм судалгааг аймгийн онцгой байдлын газар, гамшгаас хамгаалах албадын оролцоотойгоор нийт 14 аймагт “Индикаторын арга” ашиглан тойм судалгааг хийж гүйцэтгэсэн.

/Хөвсгөл, Говь-Алтай, Баян-Өлгий аймгуудын тойм судалгаа хийх ажлын хэсэгт орж ажилласан/.

Гамшгийн эрсдэлийн тойм судалгаагаар тухайн орон нутгийн мэргэжлийн байгууллагууд болон иргэдэд гамшгийн эрсдэлийн үнэлгээний талаарх мэдлэгийг олгосон сургалтыг зохион байгуулж, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн түвшинд олон нийтийн оролцоотойгоор гамшгийн 8 төрлөөр эрсдэлийн тойм үнэлгээг гаргасан.

Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийсэн аймгуудыг дараах зургаар харуулав.

Зураг 1. 2019 онд Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийсэн аймгууд²¹



Хүснэгт 1. Гамшгийн эрсдэлийн тойм судалгааны дүн, аймгаар²²

--	--	--	--	--

Д/д	Аймаг	Тойм судалгаа хийсэн огноо	Оролцогчдын тоо	Эрсдэлийн түвшин (31-60 дунд)
1	Хөвсгөл	2019.02.08 – 03.02	21	32,1
2	Говь-Алтай	2019.03.03 – 06	13	31
3	Дундговь	2019.05.01 - 05	28	52,2
4	Говьсүмбэр	2019.05.21 – 23	25	39
5	Дорноговь	2019.05.23 – 25	26	
6	Өмнөговь	2019.06.03- 06	33	40
7	Ховд	2019.06.04 - 07	43	39
8	Баян-Өлгий	2019.07.01 - 04	40	47
9	Завхан	2019.09.16 – 17	33	48,8
10	Архангай	2019.09.26 – 27	40	46,5
11	Дархан-Уул	2019.10.15 – 17	30	48
12	Баянхонгор	2019.11.07-09	48	38,5
13	Увс	2019.11.07 – 08	63	53
14	Сүхбаатар	2019.11.29	20	32,8

Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн индекс	Өнгөний илэрхийлэл
---------------------	---------------------	-----------------------

Эрсдэлийн түвшин	Эрсдэлийн индекс	Өнгөний илэрхийлэл
Бага	0-30	
Дунд	31-60	
Их	61-100	

[illegible]

12	Сүхбаатар								
----	-----------	--	--	--	--	--	--	--	--

Хүснэгтээс харахад судалгаанд хамрагдсан нийт аймгийн эрсдэл дунд түвшинд үнэлэгдсэн хэдий ч Дундговь 52.2, Баян-Өлгий 47, Увс 53, Завхан 48.8 оноогоор эдгээр аймгуудын гамшгийн эрсдэлийн түвшин бусад аймгаас харьцангуй өндөр байгаа нь харагдаж байна.

Гамшгийн эрсдэлийн тойм судалгаагаар тухайн орон нутагт гарч болзошгүй аюулын төрлийг тодорхойлох, эмзэг байдал, чадавхыг үнэлж дүн

шинжилгээ хийснээр гамшгийн эрсдэлийн түвшинг тодорхойлж, цаашид гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах үндсийг бүрдүүлдэг. Иймээс гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг хийхдээ тойм судалгааны эрсдэлийн түвшинг харгалзахаас гадна тухайн орон нутагт тохиолдож болох гамшгийн төрөл тус бүрээр гаргасан үнэлгээнд тулгуурлан боловсруулах нь илүү оновчтой юм.

ДҮГНЭЛТ

Гамшгийн эрсдэлийн тойм судалгааг орон нутгийн түвшинд, аймаг бүрээр хийж байгаа нь цаг үеэ олсон үр дүнтэй арга хэмжээ болж байна. Эрсдэлийн үнэлгээг хийснээр цаашид гарч болзошгүй аюул ослоос хохирол багатай даван туулах, гамшигтай тэмцэх чадавх сайжрах боломж бүрдэх юм. Гамшгийн эрсдэлийн тойм судалгаанд хамрагдсан аймгууд нь дунд эрсдэлийн түвшинд үнэлэгдсэн ба эдгэрээс Дундговь, Баян-Өлгий, Увс, Завхан аймгуудын эрсдэлийн түвшин харьцангуй их байна.

Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг хийхдээ тойм судалгааны эрсдэлийн түвшинг харгалзахаас гадна тухайн орон нутагт тохиолдож болох гамшгийн төрөл тус бүрээр гаргасан үнэлгээнд тулгуурлан боловсруулах нь илүү оновчтой болох нь судалгаагаар тогтоогдлоо.

Санал, зөвлөмж

- ✓ Гамшгийн эрсдэлийг индикаторын аргаар тодорхойлохдоо өгөгдсөн шалгуур үзүүлэлтүүдээр дүгнэхдээ гамшгийн төрөл тус бүр дээр шалгуур үзүүлэлтүүдийг илүү тодорхой гаргаж өгөх
- ✓ Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа хийх аргачлалыг боловсронгуй болгох, хэд хэдэн аргын хувилбар боловсруулах шаардлагатай байна
- ✓ Гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийхдээ тухайн орон нутгийн төрийн байгууллага, хувийн хэвшилд ажиллаж байгаа мэргэжилтнүүдээс гадна газар орны талаар мэдлэг бүхий иргэдийг хамруулах. /Тухайлбал, зудын эрсдэлийг үнэлэхэд малчидаас оролцуулах гэх мэт/
- ✓ Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн хуралдааныг жил бүр тогтмол зохион байгуулж, тухайн жилд шаардлагатай гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээ авах зардлыг тусгасан гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө хэлэлцэн, орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулан аймаг, орон нутгийн төсөвт тусгаж хэрэгжүүлэх,